

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр -6
Шөнө -17

УЛС ТӨР

С.ЭРДЭНЭ: МОНГОЛЧУУДЫН ХҮСЭН ХҮЛЭЭСЭН НИЙГМИЙГ АН АВЧИРЧ ЧАДНА

IV нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ХАРВОНИ ЭМИЙН ХУВЬ ЗАЯА ХААШАА ЭРГЭХ ВЭ...

V нүүрт

Дугаарын **60** мөр
ЭМД-ЫН МӨНГӨӨ ФИТНЕССТ ашигламаар байна

ҮЗЭЛ БОДОЛ

УИХ “ЭРДЭНЭТ”-ИЙН 49 ХУВИЙГ ТӨРД АВСАН НЬ БӨӨН АСУУДАЛ, ЭРГЭЛЗЭЭ ДАГУУЛЛАА

Н.БОЛД

Ажил хийж, орлого олж байгаа бүхэн татвар төлөх ёстой, уг нь. Тэр дундаа нийгмийн болоод эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг заавал төлж байх ёстой юм. Нэг ёсондоо албан журмын даатгал л даа. Ямар нэг байгууллагад ажиллаж л байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлж, ирээдүйд тэтгэвэр авах нөөцөө залуудаа бүрдүүлэх хэрэгтэй. Ажил хийгээгүй байсан ч цалингийн доод хэмжээгээр ч болов хувиар төлж байвал хэрэгтэй шүү дээ. Насны эцэст хэрэгтэй. Гэвч манай улсад энэ систем тийм ч нарийн бүрэлдэж, тогтоогүй л байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Н.ПУНЦАГБОЛД

2016 оны сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулж, парламентад 65 суудал эзэгнэсэн МАН-ын бүлэг ажлаа эхэлсэн цагаас хойшхи хамгийн зоригтой шийдвэрийг гаргалаа. Тэр нь “Эрдэнэт”-ийн 49 хувийг төрд авах. Уг нь Оросын талд байсан “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг Монголын компани худалдаж авч ирсэн. Ямар ч байсан “Эрдэнэт” үйлдвэр 100 хувь Монголын талд шилжээд байсан юм. Гэтэл Ц.Нямдорж гишүүн гэнэт л энэ хувьчлал хууль бус болсон хэмээн мэдэгдэж, “Эцсийн цамцаа урагдал зүтгэнэ” энэ тэр гэж дайрч эхэлсэн. Ингээд 49 хувийг шалгах ажлын хэсэг хүртэл байгуулагдаж, бөөн юм болов. Эцсийн дүндээ “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг Оросын талаас худалдаж авсан хүмүүсийн буруу болоод, баахан хууль зөрчсөн гэгдэж байна.

Үргэлжлэл нь III нүүрт



ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Ц.ЭЛБЭГДОРЖ: Монголын эрх баригчид хувийн өмчийг нийгэмчиллээ

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы баасан гарагийн нэгдсэн хуралдаанаар Хөгжлийн банкны тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж ирсэн. Гэвч тус банкны үйл ажиллагаа болон холбогдох бусад харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь банкны

амжилттай, үр ашигтай ажиллах боломжийг бууруулж байгаа юм. Хөгжлийн банк нь улс төрөөс хэт хараат, мэргэшсэн боловсон хүчин дутмаг, эдийн засгийн хувьд үр өгөөж багатай, нийгмийн төсөл, хөтөлбөрүүдийг хэт ихээр санхүүжүүлсэн зэрэг алдаатай үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Тиймээс дээрх алдааг засч, банкны үйл ажиллагааг төгөлдөржүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан хэмээн Засгийн газар танилцуулгадаа дурьджээ.

Үргэлжлэл нь II нүүрт

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



АШУУИС-ийн нэгдсэн эмнэлэгт ДУРАНГИЙН БҮХ ХАГАЛГААГ ХИЙХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

Н.БАТЗАЯА

Өндөр хөгжилтэй, гадаадын улс оронд очиж эмчлүүлэх хүсэлтэй иргэдийн цуваа манай улсад тасралтгүй 10 гаруй жил үргэлжилж байна гэдэгтэй хэн ч маргахгүй биз. Энэ нь зовж шаналсан иргэд хамгийн сайн эмчид үзүүлж, хамгийн сайн эмчилгээг хийлгэж хурдан эдгэрч, хөлд дээрээ босох гэсэн хүсэлтэй нь холбоотой. Үүнийг буруутгах ч аргагүй юм. Гэвч тэдний сайн хэмээн зорьж очсон эмнэлэг нь их сургуулийн эмнэлэг байдаг. Арга ч үгүй биз. Учир нь олон улсад их сургуулийн нэгдсэн

эмнэлгийг хамгийн сайн эмнэлэг гэж үздэг учраас тэр. Дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч, зорьж үйлчлүүлдэг их сургуулийн гэх тодотголтой эмнэлэг ч манай улсад байгуулагдаад олон жилийн нүүрийг үзэж буй. АШУУИС-ийн нэгдсэн эмнэлэгт манай улсын болон гадаадын доктор профессор эмч нар ажиллагдгийг байнгын үйлчлүүлэгч нар нь андахгүй мэднэ. Тус эмнэлэг орчин үеийн техник, технологийг ашигладаг бөгөөд өнгөрсөн сард гэхэд Герман улсад үйлдвэрлэсэн FENCER III дурангийн аппаратыг шинээр суурилуулжээ.

Үргэлжлэл нь VII нүүрт

АТАР

ХЭВИЙН БООВ

Ширхэгтэй дээдийн дээд гурилыг Монгол шар тосоор багсарч, далдуу модны тосонд хайрсан АТАР хэвийн боов.

Монголдоо цор ганц ТОС ШҮҮХ ТЕХНОЛОГИОР ХИЙГДСЭН

ТРАНС ТОСГУЙ БҮТЭЭГДЭХҮҮН

9811-1955, 9830-1955

Хэрэглэгчийн утас: **9333-9001**

Давно Боосон, орлогчид 099-1811-ийг хургал

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2474.00	2492.00	ФУНТ	3047.00
ЕВРО	2607.00	2680.00	РУБЛЬ	40.30
ИЕН	21.57	21.93	ЮАНЬ	360.00

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийг өргөн мэдүүллээ

УИХ-ын дарга Миеэгомбын Энхболдод УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, С.Чинзориг, Д.Цогтбаатар, Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар, Н.Энхболд нар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүллээ. УИХ-аас 1994 онд Төрийн албаны тухай хуулийг батлан 1995 оны зургадугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлсэн бөгөөд 2002 онд уг хуулийг шинэчлэн найруулж, 2008 онд хэд хэдэн зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хугацаанд нам төвтэй төрийн албыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус төрийн алба болгон өөрчлөн шинэчлэхэд ихээхэн анхаарч ирсний үр дүнд тодорхой ахиц дэвшил гарсан боловч цаашид чадахуйн зарчим / мерит/-д суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албаны эрх зүйн үндсийг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан гэж хууль санаачлагчид онцолсон юм. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа АНУ, Канад, ХБНГУ, ОХУ, БНСУ, Япон болон бусад өндөр хөгжилтэй улсуудын "төрийн алба"-тай холбогдсон хууль тогтоомж, туршлагыг судалж, өнгөрсөн хугацаанд манай улсад төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад бий болсон ололт, амжилт, туршлагад тулгуурлан боловсруулсан юм байна.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Ц.ЭЛБЭГДОРЖ: МОНГОЛЫН ЭРХ БАРИГЧИД ХУВИЙН ӨМЧИЙГ НИЙГЭМЧИЛЛЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж, УИХ-ын гишүүд болон ОУВС-гаас ирүүлсэн 13 зүйлд өөрчлөлт оруулах, зарчмын зөрүүтэй саналыг нэмэхээр тусгажээ. Тухайлбал, Хөгжлийн банк нь иргэдийн мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно, төсөл түлбөр санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх болон ТУЗ-ийн гишүүнийг нэг удаа улируулан сонгож болох бөгөөд гишүүн сүүлийн таван жилийн хугацаанд улс төрийн албан тушаал хашаагүй байх зэрэг заалтыг нэмэх санал ирүүлжээ. Уг саналыг чуулгад оролцсон гишүүдийн олонхи дэмжив. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байсангүй. Ийнхүү хуулийн төслийг батлах санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжлээ. Хуулийг энэ оны дөрөвдүгээр сарын 01-нээс мөрдөж эхлэх юм.

"Ростех"
компаниас
Ерөнхий
сайдад захидал
ирүүлсэн...

УИХ-ын чуулганы баасан гарагийн хуралдаанаар "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийн худалдан авалттай холбоотой асуудлыг хэлэлцээд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос оруулж ирсэн саналын томъёолоор санал хураалган гишүүдийн 80.3 хувь нь дэмжсэнээр УИХ-аас тогтоол баталлаа. Ингэснээр "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн мэдэлд шилжүүлэн авах шийдвэр гаргалаа. Тогтоолд УИХ-аас гаргасан дээрх шийдвэрийг Засгийн газар хэрэгжүүлж ажиллахыг үүрэг авлаа.

Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын гишүүн Г.Занданшатар, "Энэ асуудлыг хэлэлцэхэд Ерөнхийлөгч байлцах ёстой. Ерөнхийлөгч чуулганы хуралдаанд таалаараа оролцдог. Гэхдээ тухайн үед алба хашиж байсан хүмүүсээс өнөөдөр Ерөнхийлөгч л ажиллаж байна. Тиймээс Ерөнхийлөгч байр сууриа илэрхийлэх хэрэгтэй" гэсэн саналтай байгаагаа хэлсэн юм. Харин УИХ-ын гишүүн О.Баасанхүү, "ОХУ-ын "Ростех" компаниас Ерөнхий сайдад захидал ирүүлсэн гэж Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны үеэр ярьсан. Энэ захидлыг гишүүдэд тарааж танилцуулах хэрэгтэй" гэсэн саналаа хэлэхэд УИХ-ын дарга М.Энхболд, "Ерөнхийлөгч чуулганы хуралдаанд таалаараа оролцдог. УИХ-ын гишүүд

Ерөнхийлөгчийг хуралдаанд суухыг урьсан горимын санал гаргалаа гэж ажлын албанд нь дуулгачих. ОХУ-ын "Ростех" компаниас Ерөнхий сайдад ирүүлсэн захидал нь нууцын зэрэглэлд хамаарахгүй бол гишүүдэд тараахад болохгүй гэх зүйлгүй" гэсэн хариулыг өгч байлаа. Дашрамд дуулахад, өнгөрсөн баасан гарагийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны үеэр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат "Ростех" компанийн захирал Монгол Улсын Ерөнхий сайдад захидал ирүүлсэн. Тэр захидал Английн шүүхэд хандаж магадгүй шүү гэсэн утга агуулгатай байсан. Цаашид шүүхийн ямар нэгэн асуудал үүсвэл Монгол Улсын Ерөнхий газар өр төлбөр төлөхгүй шүү гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна" хэмэсэн юм.

Улмаар "Эрдэнэт" үйлдвэрийн асуудалтай холбогдуулж, энэ цаг мөчид Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж байр сууриа илэрхийлсэн юм. Төрийн тэргүүн "УИХ гэдэг бол Монголын төлөө зөвшилцөж ойлголцож асуудал шийддэг газар. Өнөөдөр яригдаж байгаа асуудлаар шийдвэр гаргах нь. Эхлээд нэг, хоёр гишүүний мэдэгдэл байсан бол одоо шийдвэр болох нь. Бид биеэ маажгаад муулаад, биенээ дийлж байгаа мэт дүр үзүүлдэг урагшилж чадахгүй. Долдугаар сарын 10-нд МҮОНТ-д өгсөн ярицлагадаа би маш тодорхой байр сууриа илэрхийлсэн. Шинэ УИХ эхний өдрийнхөө хуралдаанаар "Эрдэнэт"-ийн асуудлыг хэлэлцэх ёстой гэж. 1990 оноос хойш энэ УИХ, Засгийн газар хамгийн түрүүнд бүрдсэн. Гэтэл одоо долоон сарын дараа ярьж байгаа. Монгол Улсын нийтлэх эрх ашигт нийцэхгүй шийдвэр гаргах гэж байна. Энэ асуудлаар нээлттэй сонсгол хий гэж би хэлсэн. Нээлттэй сонсгол хийгээгүй. Тал, талаасаа ярилцаад асууж тодруулаад байхад тодорхой ойлголцолд хүрэх байх гэж найдсан. Нээлттэй сонсгол яваагүй. Засгийн газар бүрдэнгүүтээ "Эрдэнэт"-д шинэ удирдлагаа томилж, 51 нь 51 шиг, 49 нь 49 шигээ байх ёстой. Хууль дүрэм зөрчсөн бол хуулийн байгууллаагаараа шалгуулах ёстой гэдэг байр суурь би илэрхийлж байсан. "Эрдэнэт"-ийг 30 жил ажиллана гэж тэр үеийн мэргэжилтнүүд тооцсон. Өнөөдөр 39 дэх жилдээ ажиллаж байна. Өнөөдрийн хуралдаанд шиг долларын асуудал байна. Тонгог төхөөрөмж хөрөнгө оруулалт маш их шаардаж байгаа. Үүнд 500 сая ам.доллар хэрэгтэй байгаа, өмнөх шигээ ажиллахын тулд. Одоо энэ үйлдвэрийн хаалт хөгжлийн тухай ярих ёстой болсон. "Эрдэнэт" үйлдвэрийн зэс хайлуулах үйлдвэр байгуулах ёстой гэж шаардах ёстой. Баялаг нь дуусаад ирэхэд өөр шинэ үйлдвэртэй болсон байх ёстой. Үүнийг 49, 51 хувиас шаардах

...Үүний хариуд ажлын хэсгийн гишүүн Ц.Нямдорж "Ростех" хувьцаа эзэмшигч. Хуучин хоёр улсын Төрийн өмчийн хороо байсан. Хоёрдугаар сарын 09-нд гэсэн бичиг байна. Ардын намын бүлэг хуралдаанд ийм тогтоол гаргах нь зүйтэй гэж үзсэн. Өнгөрсөн оны зургадугаар сарын 13-нд Загийн газар тогтоол гаргахад ОХУ-аас яг ийм бичиг ирсэн байсан. Монгол Улсын Ерөнхий сайдтай Гадаад улсын Ерөнхий сайд л харилцах ёстой. Харилцах шаардлага байгаа юм бол сайд нь Гадаад харилцааны ямаар дамжуулаад харилцах ёстой. Нийгэмчилсэн, хувийн өмч рүү халдаад байгаа юм байхгүй" хэмээн тайлбарлаж байлаа.

Ийнхүү "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг төрийн мэдэлд авах асуудлаар санал хураахад нийт 61 гишүүн оролцлоо. Үүнээс 49 гишүүн нь "Эрдэнэт" үйлдвэрийг төрийн мэдэлд авахыг дэмжиж кноп дарсан бол 12 гишүүн эсрэг кноп дарсан юм. Тодруулбал, УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Л.Болд, Б.Дэлгэрсайхан, С.Жавхлан, Д.Мурат, З.Нарантуяа, Б.Наранхүү, Б.Пүрэвдорж, Я.Санжмятав, Ч.Хүрэлбаатар, С.Эрдэнэ, Д.Эрдэнэбат нар эсрэг кноп дарсан юм.

УИХ-ын намрын чуулганыг өндөрлүүллээ

Д.Эрдэнэбат: 1930-аад оны үеийн феодалын өмчийг хураасан шиг юм болж байна

Хэлэлцүүлгийн шатанд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат "Өнөөдрийн тогтоолыг ялын тогтоол шиг оруулж ирж байгаад харамсаж байна. Гүйцэтгэх засаглалыг ялласан, хувийн хэвшлийг, арилжааны банкнийг ялласан тогтоол. Бусдын өмчийг нийгэмчлэх тогтоол. 1930-аад оны үеийн феодалын өмчийг хураасан шиг юм болж байна. Цаг хугацаа энэ бүх зүйлийг шүүж гаргах байх. "Эрдэнэт" хязгаарлагдмал хариуцлагатай компани. Гэтэл одоо улсын өмч нэрийн дор улсын үйлдвэр

байгуулах гэж байна. Хэрвээ бид гоомой хандах юм бол Монгол Улс болон ОХУ-ын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх асуудал үүсэж болзошгүй. Ингэж шийдсэний дараа эдийн засаг, банк санхүүгийн салбарт ямар асуудал үүсэх вэ гэдгийг тооцсон зүйл байна уу" гэдгийг тодруулав. Үүний хариуд ажлын хэсгийн гишүүн Ц.Нямдорж "Ростех" хувьцаа эзэмшигч. Хуучин хоёр улсын Төрийн өмчийн хороо байсан. Хоёрдугаар сарын 09-нд гэсэн бичиг байна. Ардын намын бүлэг хуралдаанд ийм тогтоол гаргах нь зүйтэй гэж үзсэн. Өнгөрсөн оны зургадугаар сарын 13-нд Загийн газар тогтоол гаргахад ОХУ-аас яг ийм бичиг ирсэн байсан. Монгол Улсын Ерөнхий сайдтай Гадаад улсын Ерөнхий сайд л харилцах ёстой. Харилцах шаардлага байгаа юм бол сайд нь Гадаад харилцааны ямаар дамжуулаад харилцах ёстой. Нийгэмчилсэн, хувийн өмч рүү халдаад байгаа юм байхгүй" хэмээн тайлбарлаж байлаа.

Ийнхүү "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг төрийн мэдэлд авах асуудлаар санал хураахад нийт 61 гишүүн оролцлоо. Үүнээс 49 гишүүн нь "Эрдэнэт" үйлдвэрийг төрийн мэдэлд авахыг дэмжиж кноп дарсан бол 12 гишүүн эсрэг кноп дарсан юм. Тодруулбал, УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Л.Болд, Б.Дэлгэрсайхан, С.Жавхлан, Д.Мурат, З.Нарантуяа, Б.Наранхүү, Б.Пүрэвдорж, Я.Санжмятав, Ч.Хүрэлбаатар, С.Эрдэнэ, Д.Эрдэнэбат нар эсрэг кноп дарсан юм.

УИХ-ын намрын чуулганыг өндөрлүүллээ

УИХ-ын намрын чуулганыг өндөрлүүллээ. УИХ-ын дарга М.Энхболд намрын чуулганыг хааж хэлсэн үгэндээ эдийн засагт нааштай үр дүндүүд харагдаж эхэлснийг онцлолоо. Тухайлбал, валютын нөөц 1.3 тэрбум болж, ханшийн огцом өсөлтийг бууруулах нөхцөл бүрдсэн байна. Үүнээс илүү сайжруулж чадах эсэх нь УИХ, Засгийн газрын цаашидын үйл ажиллагаанаас хамаарна. УИХ намрын чуулганы хугацаанд нийгмийн халамжийн асуудалд онцгой анхаарч, холбогдох хуулиудыг баталжээ. Тухайлбал, сар шинийн өмнө 122 мянган ахмад настан тэтгэвэрээс гадна насны хишиг хүртэх болж байгаа аж. Үүнд 20.5 тэрбум төгрөг зарцуула. Тэтгэврийн зээлийн хүү жилийнх нь 18 хувь байсан бол 15 болгосон. Цаашид ч тэтгэврийн зээлийн хүүг бууруулахыг хичээж ажиллах ёстой гэлээ. Мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудлыг хэлэлцэх болоход УИХ-ын ээлжит бус чуулганыг хэдийд зарлан хуралдуулах боломжтой гэсэн юм.

МЭДЭЭЛЭЛ

Ахмадын үндэсний чуулган боллоо

"Ахмад настны эрх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын баталгаа" Үндэсний чуулган өнгөрсөн баасан гарагт Төрийн ордонд боллоо. Уг чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын ивээл дор ХНХЯ, Монголын ахмадын холбоо хамтран зохион байгуулсан юм. Чуулганд УИХ-ын гишүүн С.Чинзориг, А.Ундраа, Б.Ундармаа, яам, агентлагийн удирдлагууд болон 21 аймгаас 179, нийслэлийн есөн дүүргээс 215 төлөөлөгч оролцож байгаагийн зэрэгцээ төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын 108 зэрэг нийт 689 төлөөлөгч оролцов. Энэ үеэр ХНХ-ын сайд Н.Номтойбаяр "Ахмад настны хууль, хуулийн хэрэгжилт, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн батлагаа, Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн "Ахмад настны эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ", Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч Ц.Сүхбаатар "Ахмадын байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, ахмад настны өмнө тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам" сэдвээр тус тус итгэл тавьж, хэлэлцүүлэв. Энэ үеэр ХНХ-ын сайд Н.Номтойбаяр "УИХ-аас Ахмад настны тухай хуулийн баталж, 65-69 настанд 50 мянган төгрөг, 70-79 настанд 80 мянган төгрөг, 80-89 настанд 150 мянган төгрөг, 90-ээс дээш настай бол 250 мянган төгрөгийг "Насны хишиг" болгон жилд хоёр удаа олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Тэтгэврийн зээлийн хүү жилийн 18 хувь байсныг ХНХЯ-аас санаачлан 15 хувь болгон бууруулсан. Хүүг бууруулснаас хойш 5.5 мянга орчим ахмад настан 6.1 тэрбум төгрөгийг бага хүүтэй эзэлж авсан байна. Мөн ахмадууд тэтгэвэр авах банкаа өөрөө сонгох тогтоолдоог бүрдүүлсэн. Одоогоор 12.8 мянган ахмад настан тэтгэвэр авах банкаа өөрөө сонгосон байгаа" хэмээн илтгэлдээ дурьдаж байлаа.



АН-ын зөв томилгоо
Д.Эрдэнэбат

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өнгөрсөн баасан гарагт Төрийн ордонд хуралдлаа. Хурлаар УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга С.Эрдэнэ өөрийн хүсэлтээр бүлгийн даргаас татгалзах санал гаргажээ. Уг саналыг бүлгийн гишүүд дэмжиж, Д.Эрдэнэбатыг даргаар томилж байсан байна. Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн даргаар Д.Эрдэнэбатыг сонголоо. Энэ удаагийн томилгоог маш зөв боллоо гэх хүн олон байна. Учир нь Д.Эрдэнэбатын хувьд 2008 онд Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргын ажлыг авч намын амьдралыг дунд нь орж мэдэрчихсэн. Улмаар 2012 оны АН-ыг ялалт байгуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан. Түүнчлэн "Загарагтай, шударга, зарчимч, нэр цэвэр" гэх тодорхойлолтууд түүнийг байнга дагаж байдаг. Тиймээс намын нөхдүүдийн үнэлдэг цөөхөн хэдэн шударга улстөрчийн нэг учраас хүчтэй сөрөг хүчин байлгаж чадах биз ээ.

УЛС ТӨР

АН-ЫН ИХ ХУРАЛ

С.ЭРДЭНЭ: МОНГОЛЧУУДЫН ХҮСЭН ХҮЛЭЭСЭН НИЙГМИЙГ АН АВЧИРЧ ЧАДНА

Ж.ОТГОН

АН-ын VII их хурал “UB палас”-т өчигдөр боллоо. Өмнөх их хуралд 1000 гаруй төлөөлөгч оролцсон бол энэ удаад сум бүрээс хоёр, хороо бүрээс таван төлөөлөгч нэмэгдсэнээр энэ удаагийн хуралд 3000 гаруй төлөөлөгч оролцов. Эдгээр төлөөлөгчид АН-ын 180 мянга орчим гишүүний төлөөлөл юм. Ийнхүү хурлын эхэнд С.Эрдэнийг намын даргаар батламжлав. Тэрбээр өнгөрсөн сарын 29-нд болсон намын даргын сонгуульд нийт гишүүдийн 35.8 хувийн саналыг авч, ялалт байгуулсан билээ. Тиймээс ч түүнийг өчигдөр намын долдугаар их хурлаар батламжилж, нэрийг нь Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэхийг АН-ын ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болголоо. С.Эрдэнэд намын даргын тамга гардуулах ёслолд АН-ын дарга асан З.Энхболд, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр, нийслэлийн Ардчилсан намын дарга Э.Бат-Үүл нар оролцлоо. Энэ үеэр намын тугийг З.Энхболд, Л.Эрхэмбаяр болон Э.Бат-Үүл нарт үүрд хадгалуулахаар гардуулсан юм.



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

гишүүн бүрийн хариуцлагыг урьд өмнөхтэй харьцуулшгүй томоохон шинэчлэл боллоо. Нэгдэж, Шинэчилж, Шинийг санаачилж чадга, Оффшорчид, олигархиудаасаа салж чадсан АН-ын гишүүддээ баяр хүргэе. Ардчилсан намын гишүүний хувьд би цаашид намаа дахин эрх баригч нам болж, улс орноо хөгжүүлэх гол улс төрийн хүчин болгохын төлөө бүх хүчээ дайчлан та бүхэнтэйгээ хамтран зүтгэх болно гэдгээ амалж байна” гэсэн юм.



З.Энхболд: АН фракци, бүлэглэлийн барьцаанаас өөрийгөө чөлөөлж чадлаа

АН-ын дарга асан З.Энхболд тамгашилжүүлэх өгөх үеэрээ “АН 2016 оны УИХ-ын сонгуульд цөөнх болсон хэдий ч алдаа дутагдалдаа дүгнэлт хийж намын шинэчлэл төлөвлөлийн шинэ эринийг эхлүүлж, шинэчлэгдэж байгаа АН-аа дараагийн удирдлагадаа шилжүүлэх түүхэн үйл явдлын оролцогч, төлөөлөгч та нартаа баяр хүргэе. АН-ын шинэчлэлийн талаар товчхон мэдээлэл өгье. АН түүхэндээ анх удаа намын даргаа бүх гишүүдээс сонголоо. Энэ сонголт нь Монгол Улсын улс төрийн намуудын түүхэнд шинэчлэлийг авч ирлээ. АН фракци, бүлэглэлийн барьцаанаас өөрийгөө чөлөөлж чадлаа. АН анх удаа гишүүдийн нэгдсэн цахим бүртгэлийн сантай боллоо. Орон даяар Ардчилсан намын гишүүдийн шинэчилсэн цахим бүртгэлийг хийж чадлаа. АН үүд хаалгаа нээж чадлаа. Намын анхан ба дунд шатны байгууллагуулыг өөрийн хүрээллийн хэдхэн хүнээр бэхжүүлж, үүд хаалгаа хаадаг тогтолцоо өнөөдрөөс эхлэн нуран унаж байна. Дотоод сонгууль нээлттэй, ил тод болж чадлаа. Дүрмийн шинэчилсэн төслөөр намын дарга, аймаг дүүрэг, сумын дарга, үндэсний бодлогын хорооны гишүүнийг бүх гишүүдээс сонгодог болсон нь гишүүдийн оролцоо эрхийг нэмэгдүүлж, улс төрийн намын

“АН шинэчлэгдэхийн хэрээр Монгол орон хөгжинэ”

Харин АН-ын дарга болсон С.Эрдэнэ гишүүддээ хандаж хэлсэн үгэндээ “1989 оны жавар тачигнасан өвлөөс эхлэн та бид ардчиллын үнэт зүйлийнхээ төлөө тэмцлээ. Өөрчлөн байгуулалтыг хийх түүхэн замналыг туулахад амар хялбар байгаагүй. Ардчиллын үнэт зүйлийн төлөө тэмцэж явсан олон журмын нөхөд маань өнөөдөр алга. Бид өнөөдөр түүхэн шалгуурын өмнө ирчихээд байна. Монголын ардчиллыг

авч явах хариуцлага шалгуур ирээд байна. Монголын хөгжлийн бодлогыг тодорхойлох улс төрийн хариуцлага дээр ирчихээд байна. Өнөөдрийн эрх баригч хүчин монголчуудын хүсэн хүлээж байгаа ч болж, АН ялагдал хүлээсэн гэдгийг олон хүн хэлдэг. Тэгвэл намын даргын суудлаас бууж буй тэрбээр “Ардчилсан намыг фракци, бүлэглэлийн барьцаанаас чөлөөлж чадлаа” хэмээн нүүр бардам хэлж буйгаас харахад энэ намыг шинэчлэх үйл явцад гол тээг болж ирсэн асуудал үнэхээр үгүй болгов уу гэх найдлагыг мянга мянган гишүүддээ төрүүлж байсан юм.

Бид хувийн хэвшлийг хүндэтгэдэг нийгмийг бий болгоно” гэлээ. Ийнхүү АН ялагдалдаа цэг тавьж, З.Энхболдыг чөлөөлж, шинэ даргаараа С.Эрдэнийг батламжиллаа. Шинэ даргын хувьд одоо АН-ыг цоо шинэ болгох даалгавар дээр буулаа. Өөрөөр хэлбэл, шинэчлэлийн суурийг өмнөх дарга эхлүүлээд явлаа. Харин одоо С.Эрдэнэ шинэчлэлийг хөрсөн дээр нь буулгаж, ажил хэрэг болгож чадах уу гэдгийг харах л үлдлээ.

АН-ын дүрмийн дагуу эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэнэ гэв

Ардчилсан намын VII их хуралд оролцож байгаа зарим зочдын байр суурийг сонссон юм. УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл “Намын дүрмийн төслийг маш удаан хугацаанд намын бүх гишүүдээр хэлэлцүүлсэн. УИХ-ын сонгуулийн дараагаас намын шинэчлэл эхэлсэн. АН бүх гишүүдийн оролцоотойгоор шинэ даргаа сонгосон. Намын бүх шатны удирдлагуудыг шинэчлэх, томилгоо асуудал дэс дараатайгаар хийгдэнэ. АН-ын дүрмийн дагуу эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэх нь гэсэн өөдрөг үзэлтэй байна. Үндэсний бодлогын хорооны

гишүүдэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, оролцоо нэмэгдэж байна. Ардчилсан нам УИХ-д чанартай эмэгтэйчүүд бэлтгэх ажлаа эхлүүлж байна. Мөн намын шинэ дарга С.Эрдэнэ өөрөө эмэгтэйчүүдэд ээлтэй улстөрч. Эмэгтэй гишүүдээ дэмжих, манлайллын төвшинд гаргаж ирдэг учраас эмэгтэйчүүдийн итгэлийг төрүүлж байна” гэлээ. Харин нийслэлийн Ардчилсан намын дарга Э.Бат-Үүл “С.Эрдэнэд өмнөх намын даргаас илүү эрх мэдэл, итгэл найдвар очиж байгаа. Монголд хэзээ ч урьд өмнө ийм олон гишүүдийнхээ саналаар намын дарга болсон жишиг байхгүй. С.Эрдэнэ анхдагч нь. Монголд ийм сунгаа хийж чадаж нам хаана ч байхгүй. Коммунист нам байснаа нууж явдаг МАН хэзээ ч ийм сунгаа хийж чадахгүй. Компаний нам болж байсан нам хэзээ ч ийм сунгаа хийж чадахгүй. Бүс нутагт ч ийм нам байхгүй гэдгийг бардам хэлж чадна” хэмээсэн юм. Мөн Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр “Одоо АН сэтгэлгээний шинэчлэл рүү явах цаг нь болсон. Бид эх орныхоо төлөө зөв хүмүүжилтэй, боловсролтой, хөдөлмөрийг тахин шүтдэг хүмүүсээр манлайлуулах ёстой. Тиймээс АН-ыг сэтгэлгээний шинэчлэл рүү хөтлөхийг захиж байна. Маш том хариуцлага үүрлээ шүү. Амбийц хувиа бодох юм байхгүй, эх орныхоо төлөө, иргэдийнхээ төлөө хамтдаа явцгаая С.Эрдэнэ ээ” хэмээв.

Намын дүрмийн төсөлд ямар онцлог өөрчлөлтүүд орж байна вэ?

“Ардчилсан намын шинэчлэлийн анхны алхам амжилттай болж байна. Өнөөдрийн хурлаар АН-ын дүрмийн өөрчлөлт батлах ёстой. Ингэснээр намын анхан дунд шатны намын үүрийн дарга нар өөрчлөгдөж эхэлнэ. УЗХ отгон хуралдаанаа хийж, их хурлаар хэлэлцэх асуудлаа батлаад албан ёсоор тарсан. УЗХ-г Үндэсний бодлогын хороо болгон өөрчилж, 380 төлөөлөгч бүхий бодлогын том хороо байгуулагдана. 338 үүрийн дарга нар, аймаг, хороодын тэргүүлэгчид шинэчлэгдэхээс гадна аймаг, дүүргийн намын дарга нарыг шинээр томилох зэрэг намын шинэчлэлийн хоёр дахь том ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна. Түүнээс гадна АН-ын дараагийн их хурлаар Үндсэн дүрмийг эцэслэн батална. Энэ хугацаанд Үндсэн дүрэмд хийх зохицуулалт, Үндсэн дүрмийг хийх ажлын хэсэг байгуулж, хоёр сар гаруйн хугацаанд хэлэлцүүлэх шаардлагатай байгаа.

Намын ерөнхий нарийн бичгийн даргыг хэзээ тодруулах вэ?

“Өнөөдөр үдээс хойш /өчигдөр/ дүрэм батлагдсаны дараа Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг ярилцана. Дүрэм батлагдсаны дараа намын дарга санал болгосноор Ерөнхий нарийн бичгийн даргыг VII их хурлын төлөөлөгчид сонгоно.

Хэдийгээр АН-ын дарга С.Эрдэнэ өчигдөртөө багтаан АН-ын ерөнхий нарийн бичгийн даргыг оруулж, батламжуулна хэмээх тайлбарыг үдээс өмнөх хуралдааны үеэр өгч байсан ч чадсангүй. Гэхдээ намын ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг шинэ даргад өгсөн юм. Тиймээс ирэх долоо хоногт багтаан генсекээ томилох биз ээ. Дээрх хуралдаанаас Ардчилсан намын VIII их хурлыг тавдугаар сарын эхээр хийхээр товллоо.

Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн даргыг томилсонгүй

Ийнхүү АН VII их

Хууль зүй, дотоод хэргийн яам ямар ажил амжуулав

Хууль Зүй, дотоод хэргийн яам өнгөрсөн нэгдүгээр сард хийсэн ажлын тайлангаа гаргажээ. Тодруулбал, УИХ-ын намрын чуулган завсарлахаас урьтаж, нэлээд хэдэн хууль батлуулж, чадсан яам юм. Арбитрын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг тус, тус УИХ-аар батлуулжээ. Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дотоодын цэргийн тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай, Зөрчлийн тухай шинэчилсэн найруулга, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлсэн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслүүдийг, Сайдын зөвлөлийн хуралдаанаар Прокурорын тухай, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг хэлэлцүүлсэн байна. Засгийн газрын нийт 40 тогтоолын төсөлд холбогдох санал боловсруулан хүргүүлжээ. Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн сан бүрдүүлэх, лавлагаа өгөх журмын дагуу дөрвөн байгууллага, 13 иргэнд 39 лавлагаа өгчээ.

Есөн журам боловсруулжээ

Хууль зүй, дотоод хэргийн сайд ТТАХНЭ, Хорих 461 дүгээр ангийн үйл ажиллагаатай танилцаж ШШПГГ-ын төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, үүрэг чиглэл өгөв. Монголбанкнаас ирүүлсэн, Монгол Улсын мөнгө угаах, терроризм болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хийж буй Харилцан үнэлгээний тайланд санал өгчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан “Хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох, хамгаалах журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээний журам”, “Гэр бүлийн хүчирхийллийн талаар статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам” гэх мэтчилэн нийт есөн төслийг боловсруулжээ.

Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэв

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний биелэлтийн явцыг байгууллагуудаас ирүүлсэн тайлан мэдээгээр гаргаж, ерөнхий

төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус Зөвлөлийн хурлыг зохион байгуулжээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хоёр дахь компакт гэрээний шинжээчдийн баг, Азийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Мелони К.Линдбэрг, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Жэймс Андерсон, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын ШШПГГ-г 2014-2016 онд хэрэгжүүлсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, чадавхийг бэхжүүлэх” төслийн хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээч нартай хийсэн уулзалтуудыг зохион байгуулжээ. Тайлангийн хугацаанд эрх зүйн туслалцааны 24 (БНКАЗУ-2, ОХУ-4, БНПУ-2, өмнөх онд ирүүлсэн байсан БНКУ-10, БНБУ-1, ОХУ-5) хүсэлтэд ажиллагаа хийж, хариу хүргүүлсэн байна. АНУ-ын Төрийн департаментын Олон улсын мансууруулах бодис, хууль

сахиулах үйл ажиллагааны товчооны санхүүжилтээр ОУЭХБ-тай хэрэгжүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх төслийг үргэлжлүүлэхээр дараагийн төслийн үйл ажиллагааны саналыг АНУ-ын талд хүргүүлэв.

Иргэдэд лавлагаа өгөв

Захиргааны хэм хэмжээний нийт 25 актыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж 14 актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, хоёр актад дүгнэлт хүргүүлж, гурван актын нэмэлт, өөрчлөлтийг санд хүлээн авч, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй дөрөв, хуульд заасан бүрдлийн шаардлага хангаагүй хоёр актыг холбогдох байгууллагуудад нь буцаажээ. Түүнчлэн “Захиргааны ерөнхий хууль”, “Захиргааны хэм хэмжээний акт” сэдвээр хоёр удаагийн сургалтыг ОБЕГ, Говь-

хуралдаанаараа намын дүрэм, Ардчилсан намын даргыг ёсчлон баталж чадлаа. Мөн анхан болон дунд шатны намын удирдлагуудыг шинэчлэх, намын Үндэсний зөвлөлдөх хорооны нэр, гишүүдийг өөрчлөн Үндэсний бодлогын хороо болголоо. Ингэснээр өмнөх Үндэсний зөвлөлдөх хороо Үндэсний бодлогын хороо болж нэрээ өөрчлөн, 380 төлөөлөгчтэй болж байгаа юм. Харин Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг хэлцсэнгүй.

Хурлын үеэр АН-ын дарга С.Эрдэнээс зарим зүйлийг тодруулсан юм.

Намын дүрмийн төсөлд ямар онцлог өөрчлөлтүүд орж байна вэ?

“Ардчилсан намын шинэчлэлийн анхны алхам амжилттай болж байна. Өнөөдрийн хурлаар АН-ын дүрмийн өөрчлөлт батлах ёстой. Ингэснээр намын анхан дунд шатны намын үүрийн дарга нар өөрчлөгдөж эхэлнэ. УЗХ отгон хуралдаанаа хийж, их хурлаар хэлэлцэх асуудлаа батлаад албан ёсоор тарсан. УЗХ-г Үндэсний бодлогын хороо болгон өөрчилж, 380 төлөөлөгч бүхий бодлогын том хороо байгуулагдана. 338 үүрийн дарга нар, аймаг, хороодын тэргүүлэгчид шинэчлэгдэхээс гадна аймаг, дүүргийн намын дарга нарыг шинээр томилох зэрэг намын шинэчлэлийн хоёр дахь том ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна. Түүнээс гадна АН-ын дараагийн их хурлаар Үндсэн дүрмийг эцэслэн батална. Энэ хугацаанд Үндсэн дүрэмд хийх зохицуулалт, Үндсэн дүрмийг хийх ажлын хэсэг байгуулж, хоёр сар гаруйн хугацаанд хэлэлцүүлэх шаардлагатай байгаа.

Намын ерөнхий нарийн бичгийн даргыг хэзээ тодруулах вэ?

“Өнөөдөр үдээс хойш /өчигдөр/ дүрэм батлагдсаны дараа Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг ярилцана. Дүрэм батлагдсаны дараа намын дарга санал болгосноор Ерөнхий нарийн бичгийн даргыг VII их хурлын төлөөлөгчид сонгоно. Хэдийгээр АН-ын дарга С.Эрдэнэ өчигдөртөө багтаан АН-ын ерөнхий нарийн бичгийн даргыг оруулж, батламжуулна хэмээх тайлбарыг үдээс өмнөх хуралдааны үеэр өгч байсан ч чадсангүй. Гэхдээ намын ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг шинэ даргад өгсөн юм. Тиймээс ирэх долоо хоногт багтаан генсекээ томилох биз ээ. Дээрх хуралдаанаас Ардчилсан намын VIII их хурлыг тавдугаар сарын эхээр хийхээр товллоо.

Сургалт зохион байгууллаа

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Улаанбаатар хотын цагдаагийн газартай хамтран албаны сургалт хийв. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуулийн хэрэгжилтийг хангах, уг бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг эрчимжүүлэх, түүний хор хөнөөлөөс хүн амын удмын санг хамгаалах, чиг үүрэг бүхий байгууллагыг чадавхижуулах, алба хаагчдыг мэрхэшүүлэх зохион байгуулах уулзалт боллоо.

ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

ХАРВОНИ ЭМИЙН ХУВЬ ЗАЯА ХААШАА ЭРГЭХ ВЭ...

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд АНУ-ын “Гилеад Сайнс” компаниас буцалтгүй тусламжаар нийлүүлж буй 928.110 ам.долларын өртөг бүхий 3000 хайрцаг “Харвони” эмийн гаалийн болон НӨАТ болох 354.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар болсон. Өөрөөр хэлбэл, АНУ-ын “Гилеад Сайнс” компани нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд өвчлөл өндөртэй, бага орлоготой иргэдийн дунд хэрэгжүүлдэг хөтөлбөрийнхөө дагуу Архангай аймгийн 45-60 насны С вирусын халдвартай иргэдэд “Харвони” эмийг үнэ төлбөргүй олгохоор шийдвэрлэсэн юм. Иймд буцалтгүй тусламжаар нийлүүлж буй 3000 хайрцаг эмийн холбогдох татварыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, Архангай аймагт холбогдох хууль журмын дагуу, мэргэжлийн эмчийн хяналт дор иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулахаар болсон хэрэг. Гэтэл ганцхан аймагт “Харвони” эмийг гарах гэлээ хэмээн асуудал үүсэх болсон. Тиймээс энэ удаагийн “Онцлох хуудас” булангаараа “Харвони” эмтэй холбоотой асуудлыг онцолж байна.

Б.Өсөхбаяр: “Оном сан” бизнесийн орчноо алдахгүйн тулд эсэргүүцэж байгаа

/Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга/

“Оном сан” гэдэгт өндөртэй үнэтэй эм зардаг, элэгний эмчилгээ хийдэг, шинжилгээ авдаг хувийн эмнэлгүүд харьяалагддаг. Тиймээс тэд бизнесийн орчноо алдахгүйн тулд гаднаас орж ирэх хандив тусламжийг үгүй хийх зорилгоор ингэж эсэргүүцэж байгаа юм. Тэд бусдад буруу ташаа мэдээлэл цацаж байна. Буруу гэдгийн учрыг тайлбарлавал энэ нь ямар нэгэн Засгийн газар, хоорондын гэрээ хэлцэл, зээл тусламж биш. Ё.Баатарбилэг гишүүний хувийн журмаар хөөцөлдөж байгаад тойргийнхоо иргэдэд тараах, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, зорилгоор хийж хэрэгжүүлж буй ажил. Харин гаалийн татварыг Засгийн газрын шийдвэрээр дундуулсан. Элэгний өвчлөл манай улсад маш их болсон. Өвчин их байх тусам цаад хувийн эмнэлгүүдэд ашигтай байдаг. Тиймээс тэд бизнесээ алдахгүйн тулд тэмцэж байна. Яагаад гэхээр энэ хөтөлбөр Архангай аймагт амжилттай хэрэгжихвэл бусад аймгуудад ийм хөтөлбөр хэрэгжүүлэхээр АНУ-ын энэ компанитай ярьж байгаа юм. Үүнийг мэдчихээд эмнэлгүүдээ дампууруулахгүйн тулд Д.Наранбаатар зэрэг хүмүүс юу гэж ч худал мэдээлэл тараахад бэлэн байх шиг байна. Би хувьдаа гайхаж байна. Үнэхээр хүний эрүүл мэндийн төлөө яваа юм бол нэг ч гэсэн хүн эрүүл болж байвал сайн баймаар юм. Үнэхээр хүний эрүүл мэндийн төлөө ажилладаг санаа тавьдаг юм бол Д.Наранбаатар яагаад энэ хөтөлбөрийг эсэргүүцдэг байгаа юм. Уг нь нэг аймаг ч гэсэн элэгний өвчлөлтгүй болж байвал сайн биз дээ. Тэд гадны хөрөнгө оруулалтыг аль болох оруулахыг хүсэхгүй байна. Үргэх гэж буй оролдлого. Энэ бохир арга нь үйлчлээд, АНУ-ын энэ эм өгч буй компани танай улсынхан үнэгүй эм өгч байхад хэрүүл хийцгээдэг ямар сонин хүмүүс бэ гээд гайхаж, үргэж эхэлж байна.

Л.Мөнхтулга: Ингэж улстөржих хэрэггүй

/ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга/

УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг 2016 оны тавдугаар сард “Элэгний эмгэггүй Архангай” гэсэн төсөл санаачилж, АНУ-ын “Гилеад Сайнс” компанийн төлөөлөгчидтэй уулзсан юм билээ. Тэгэхдээ “Архангай аймагт элэгний өвчлөл өндөр байгаа учраас “Харвони” эмнээсээ хандивлаач” гэсэн санал тавихад тус компанийнхан зөвшөөрсөн. Ингээд 6000 хайрцаг “Харвони” эмийг үнэ төлбөргүй олгохоор болсон байна. Төслийн хүрээнд эхний ээлжинд 3000 хайрцаг эм хүргүүлсэн. ЭМЯ чиг үүргийнхээ дагуу энэ асуудлыг Засгийн газраар хэлэлцүүлэн тэдгээр эмийг гааль, татвараас чөлөөлүүлсэн. Манай яамнаас “Элэгний С вирусгүй Монгол” хөтөлбөр боловсруулж, ажлын хэсэг гарч ажиллаж байна. Аймаг, сумын нь төлөөллийн хэн нь ч ийм төсөл хэрэгжүүлэх боломжтой. Ингэж улстөржих хэрэггүй.

Д.Наранбаатар: Элэгний хорт хавдрын өвчлөлөөрөө Архангай аймаг хамгийн бага

/“Оном” сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, доктор/

Монгол Улсад нэгдсэн бодлого гэж байх ёстой. Нэг л Монгол улс, ижилхэн л монголчууд. Архангайн Монгол, Сүхбаатарын Монгол гэж байхгүй. Сүхбаатараас сонгогдсон гишүүн арчаагүй болохоор иргэд нь үнэгүй эм авч чадахгүй. Архангайн гишүүн бол “Би таныг аварч байна” гэж хэлж байна шүү дээ. 2020 он гэхэд элэгний С вирус бүрэн устгахын тулд 150 мянган хүн эмчилнэ гэсэн үг. Өнгөрсөн жил 7000 гаруй хүн энэ эмийг уугаад эмчлэгдсэн. ДЭМБ-аас гаргасан мэдээгээр өнөөдөр манай улсад шинээр 3000 хүн элэгний С вирусын халдвар авч байна. Тэгэхээр бид урагшаа хоёр алхаад, арагшаа нэг алхам ухарч байна. Ер нь 76 гишүүн нь энэ эмчилгээг 76 тойрог руугаа татах уу, 76 монгол болох уу. Эрүүл мэндийн салбарынхан бол ажлаа хийж байгаад л халдвар авсан. Энэ хүмүүсийг эмчлээд дахин шинэ хүнд халдвар өгөх магадлалыг багасгамаар байна шүү дээ. Тэгж байж бид зорилгодоо хүрнэ, элэг бүтэн болно. Манай улс элэгний вирусын тархалтын судалгааг одоо хүртэл хийгээгүй. 2013 онд “Оном” сангийн эрдэмтэд Завхан, Өвөрхангай, Дорноговь аймагт элэгний вирусын тархалтын судалгаа хийсэн. Энэ талаар хийсэн хамгийн сүүлийн судалгаа бол тэр. Бид гадаадаас мөнгийг нь босгож байж судалгаа хийсэн. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвөөс жил бүр гаргадаг “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд-2016” эмхэтгэлд элэгний хорт хавдрын өвчлөлөөрөө Архангай аймаг хамгийн бага байгаа. Бид элэгний вирусын халдварыг өвчлөл, нас баралтаар нь л барагцааж байна. Архангайд очиход сумаар нь ялгаварлан гадуурхана. УИХ-ын гишүүн Баатарбилэгийн сонгогдсон сумдад илүү хуваарилж таарна. 45-60 насныханд өгнө гэж насаар нь ялгаварлан гадуурхана. В, Д вирусын халдвартай цэл залуухан хүмүүс элэгний хатуурал, элэгний хорт хавдраас болж, элэг шилжүүлэн суулгуулахаас аргагүйд хүрч байна. Тэр хүмүүст тусалмаар байна. Тоо баримтлах харахад 45-аас дээш насны 22 мянган хүн байна. Түүний 10 хувь гэж тооцоод 2000 эм авахад хангалттай юм байна гэж үзсэн бололтой.

А.Цогцэцэг: Эрүүл мэндийн сайдын хувьд нутгархаад суух боломжгүй

/Эрүүл мэндийн сайд/

Архангай аймгийн хувьд Эрүүл мэндийн газар нь “Элэгний эмгэггүй Архангай” төсөл боловсруулж, УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэгт хүргүүлсэн юм билээ. Тухайн аймагсаас сонгогдсон УИХ-ын гишүүний хувьд нутгийнхаа иргэдийн эрүүл мэндийн төлөө хүсэлтийг нь харгалзан үзэж, дэмжин ажиллаж, АНУ-ын “Гилеад Сайнс” компанитай холбоо тогтоож, элэгний С вирусын 3000 хайрцаг, 1000 хүн тун эмийг буцалтгүй тусламжаар авах боломжтой болсон юм байна. Уг асуудлаа Эрүүл мэндийн яаманд уламжилж, 2016 оны аравдугаар сарын 17-ны өдөр Эрүүл мэндийн сайдад хүсэлтээ ирүүлсэн. Үүнийг Засгийн газар дэмжиж, “Харвони” эмийн гаалийн болон НӨАТ-ыг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар болсон юм. Үүнээс өмнө ЭМЯ-наас “Оном сан” ТББ-д “IDIS” олон улсын байгууллагаас буцалтгүй тусламжаар 50 иргэнд үнэ төлбөргүй олгох гепатитын С вирус эмчлэх “Викира Пак” 300 хайрцаг эмийг импортлох лиценз олгож, гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тал дээр дэмжлэг үзүүлж өгөх тухай Сангийн яаманд албан тоот хүргүүлж байсан. Ер нь салбарын бодлогыг хэрэгжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд Эрүүл мэндийн сайдын хувьд нутгархаад суух боломжгүй. Бид иргэдээ л гэсэн сэтгэлийн үндсэн дээр ажиллаж байна. АНУ-ын “Гилеад Сайнс” компанийн элэгний С вирус эмчлэх “Харвони” эмийн нэг сарын хэрэглээний өртөг 400 ам.долларын үнэтэй байсныг 300 доллар болгон үнийг бууруулж, хүртээмжийг нь нэмэгдүүлсэн. 2016 оны арванхоёрдугаар сараас эхлэн Засгийн газрын шийдвэрийн дагуу гепатит С вирус эмчлэх “Харвони” эмээс гадна ижил үйлчилгээ бүхий дөрвөн нэрийн эмийг худалдан авахад Эрүүл мэндийн даатгалын сангаас сарын хэрэглээ тутмаас 210 мянган төгрөг, гурван сар буюу нэг курс эмчилгээний эмийн өртөг нийт 630 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байна.

Ё.Баатарбилэг: Төсөл зогсвол энэ нэг хашгичаад байгаа залуу хариуцах юм уу

/УИХ-ын гишүүн, Архангай аймгийн Засаг дарга асан/

Энэ нэг “Элэг бүтэн Монгол” гээд яваад байсан хэн ч билээ нэг залуу ойрд “Бурхангүй газрын бумба” шиг л “галзуурч” байна аа. Эрүүл мэндийн сайд нь ч томоотой юм хөөрхий, номхон тэмээ мэт. Би уг нь өнгөрсөн зун АНУ-ын “Гилеад Сайнс” компанийнхантай холбоо тогтоогоод, биечлэн уулзаад миний сонгогдсон тойрогт элэгний өвчлөл их байгаа тул “Харвони” эмнээсээ хандивлаач гэсэн хүсэлт тавьж, тэд ч удалгүй хариу өгч зөвшөөрсөн юм. Нэг нөхцөлтэй. Эхний ээлжинд зөвхөн танай Архангай аймгийн ахмадуудад гэж. Нийт 3000 хүнийхнийг. Бас шинжилгээний зардлаа танайх хариуцаарай гэж. Бид ч баруулаад аймагтаа төслийн ажлын хэсэг байгуулж бүх ажлаа зохион байгуулж долоон сар шахам ажиллаж байж эхний ээлжийн 1000 ширхэгийг авах болж байна. Яг энэ төслийн ажлын хэсгийг би өөрөө аймагтаа очиж гардан зохион байгуулж, удирдлага чиглэлээр хангаж ажилласан. Засгийн газар дэмжиж хандиваар ирж байгаа тул татварыг хөнгөлсөн. Ийм л энгийн юм. 1000 ширхэг Харвони манайд байгаа зах зээлийн үнээрээ 900.000 доллар буюу хоёр тэрбум 300 гаруй сая төгрөг. Одоо нэг санаа зовоосон асуудал байна манайхаан. Хүн хөөцөлдөөд юм олж ирэхээр “яахаараа чи гэж” гээд хувааж тараа, адил хүртэх ёстой гээд нийгэмчлэх гээд байдаг сэтгэлгээ хэвээр байна. Өөрсдөө ингээд юм олж ирэх боломж дэлхийгээр нэг байна. Яваад олоод ирээч дээ. Хэн байг гэсэн юм. Бас нэг асуудал нь энд ингээд попдоод байхаар нөгөө АНУ-ын компани бизнесийн нэр хүндээ бодоод төслийн дараагийнхаа амласныг өгөхгүй болох тал руугаа яриа хэлбийгээд эхэллээ. Яана вэ? Төсөл зогсвол энэ нэг хашгичаад байгаа залуу хариуцах юм уу. Ард нь турхирдаг хүмүүс хариуцах юм уу. Архангайн ард иргэдийнхээ нэрийн өмнөөс энэ байл явуулгаа зогсоохыг шаардаж байна. Үнэхээр элэгний өвчлөлийн эсрэг явж байгаа юм бол үйлдэл чинь үгтэйгээ нийцэхгүй байна. Хэдэн хүнд ингэж үнэгүй эм хандивласнаа яриач залуу. Улсын төсвөөс хөнгөлөлт үзүүлж байгааг ярихгүйгээр шүү. Сая шинжилгээгээр Архангайн ахмадуудын дундах С вирусын өвчлөл 19 хувь буюу улсын дунджаас асар өндөр гарсан.



Сэтгүүлчийн өнцөг

АРХАНГАЙ БИТГИЙ ХЭЛ НЭГ Ч МОНГОЛ ХҮН ХАРВОНИ ЭМИЙГ АВАХ ЭРХГҮЙ БОЛОХ НЬ

Ж.ОТГОН

ДЭМБ-аас 2030 он гэхэд элэгний В, С вирус бүрэн устгаж, нийгмийн эрүүл мэндийн аюул биш болгоно гэсэн зорилт тавьжээ. Харин манай улс “2020 он гэхэд элэгний С вирус устгана” гэсэн зорилт тавьж, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд “Архангай аймгийн Эрүүл мэндийн газраас “Элэгний эмгэггүй Архангай” төслийг боловсруулж, 2016 оны аравдугаар сарын 10-ны өдөр УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэгт хүргүүлсэн байна. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Архангай аймагсаас сонгогдсон УИХ-ын гишүүний хувьд тэрбээр нутгийнхаа иргэдийн төлөө хүсэлтийг нь харгалзан үзэж, тэдний ирүүлсэн төслийг дэмжин ажилласан аж. Улмаар УИХ-ын

гишүүн Ё.Баатарбилэг АНУ-ын “Гилеад Сайнс” компанитай холбоо тогтоож, элэгний С вирус болгохын тулд хамаг бүхнээ зориулан зүтгэж байгаа гэх “Оном” сангийн ТУЗ-ийн дарга Д.Наранбаатар гэх нөхөр энэхүү элэгний эмний асуудлаар сүүлийн хэдэн хоног “поп”-дож эхлээд байгаа. Тэрбээр “Ё.Баатарбилэг гишүүн, А.Цогцэцэг сайд нар Архангайн монгол биш, Монголын монгол хүн юм бол тэнд байгаа амьдралын боломжтой хүмүүст

үнэгүй эм тарааж яах юм бэ. Хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу, орлоготой, энэ эмийг авч уух мөнгөгүй хүмүүст өгч болно шүү дээ. Хүн юм бол үүнийг ойлгох ёстой. Архангайн мянгат малчинд тараах ямар хэрэгтэй юм бэ. Энэ бол А.Цогцэцэг сайд Шогцэцэг болж байгаагийн илрэл. Энэ хүн Монгол Улсын Эрүүл мэндийн сайд биш, Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга байх ёстой хүн байна” хэмээн эгдүүцэж, асуудал үүсгэх болсон. Тэгвэл энэхүү эмийг Архангай аймгийн иргэдэд буцалтгүй тусламжаар өгөхөөр болоод байгаа Америкийн компани гааль дээр байгаа Харвони эмийг буцаан татаж магадгүй болоод байна. Тодруулбал, АНУ-ын “Гилеад Сайнс” компаниас Монгол дахь дистрибутор компани болох “Омбал” ХХК-ийн удирдлагуудад “Гааль дээр байгаа 1000 хүний

Харвони эмийг татаж оруулахаа азнаж байгаарай, хэрэв Монгол Улсын Засгийн газраас манай компанийн хэрэгжүүлж байгаа төслийг ямар нэг байдлаар өөрчлөх гэвэл бид татан авах нөхцөл үүсч болзошгүй” гэж мэдэгдсэн талаар уг төслийг санаачлагч УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг мэдэгдсэн. Тиймээс Архангай аймгийн ахмад настнуудад элэгний С вирус Харвони эмийг түүгээх зорилготой эхлүүлсэн төслийн зорилгыг Д.Наранбаатар мэтийн хэсэг нөхдүүд үлстөржүүлж, гуйвуулж, иргэдэд буруу мэдээлэл өгч, дэлхийгээр нэг тарааж шуудсаны үр дүнд Архангай битгий хэл нэг ч монгол хүн харвони эмийг авах эрхгүй болох эгээгтэй байдал үүсч байгаа гэсэн үг. Үнэхээр УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэгийн хэлээд байгаа шиг энэхүү төслийн ажил зогсчихвол хэн хариуцлага хүлээх бол. Мэдээж асуудал

үүсгээд яваа Д.Наранбаатар гэх нөхөр лав хариуцлага хүлээхгүй гэдэг нь ойлгомжтой. Учир нь тэрбээр монголчуудыг элэгний өвчлөлөөс салгах гэсэндээ биш, харин ч элэгний өвчтэй хүмүүсийг бөөн мөнгө болгож хардаг нэгэн байж ч магадгүй болж байна. Өмнө нь 300 хайрцаг “Viekira Pak” (3D) эмийг 50 хүнд үнэ төлбөргүй олгохоор АНУ-аас оруулж ирж байсан байгаа юм. Ингэхдээ Д.Наранбаатар Эрүүл мэндийн яаманд хүсэлт гаргаж, Сангийн яамнаас гаалийн НӨАТ-аас чөлөөлүүлсэн гэж байгаа. Хачирхалтай нь, НӨАТ-аас чөлөөлсөн 300 хайрцаг эм ямар шугамаар иргэдэд хүрсэн нь өнөөдрийг хүртэл тодорхойгүй. Магадгүй “Оном” сангаар дамжуулан авсан эмээ иргэдэд үнэтэй зарчихсан ч байж магадгүй нэсэн хардлага явж эхлээд байгаа гэсэн. Учир нь, тус сангийн

байранд байгуулсан лабораторид шинжилгээнд ороход 6000 төгрөгийн ханштай байдаг гэж байгаа. Уг нь бол энэ төрлийн шинжилгээг 1000 төгрөгөөр хийдэг гэсэн. Энэ мэтээс харж байхад Д.Наранбаатар гэх нөхөр тийм ч сайхан “энхийн цагаан тагтаа” биш бөгөөд энэ бүх шуудалтын цаана юу нуугдаж байгаа нь ойлгомжтой болж байгаа юм. Тэгэхдээ ч Архангай аймгийн иргэд ч монгол хүн шүү дээ. Тиймээс энэ мэт буруу мэдээллийг нийгэмд түгээж, барин тавин мэдээлэл хийж, буцалтгүй тусламжаар орж ирэх гэж байгаа эмийн хувь заяаг харуулаад байгаа үйлдлээ яаралтай зогсоовол зүгээр байна. Нэг хүний бизнесийн ашиг сонирхлоос болж нэлээд олон хүний буюу 3000 монгол хүний эрүүл мэндийн асуудлаараа наадуулаад байж болох уу.

ДЭЛХИЙ



БНАСАУ

ЯПОН ТЭНГИС РҮҮ ПУУЖИН ХАРВАЛАА

Б.ДАВААХҮҮ

БНАСАУ японы цагаар очигдөр өглөө 07.55 цагийн үед баруун хойд хэсгийн Пёнъян-аас нэг удаа пуужин харважээ. Пуужин 500 орчим км нисээд Япон тэнгист унасан байна. Японы Батлан хамгаалах яамны албаны эх сурвалжийн мэдээлснээр тус пуужин 1300км-т тусах хүчин чадалтай "Нодон" ангилалын баллистик пуужин байж магадгүй гэнэ. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын урилгаар Флорида мужид айлчилж буй Японы Ерөнхий сайд Шинзо Абэ ч пуужин харвасантай холбогдуулан хэвлэлийн хурал зарлаж, "Хүлээн зөвшөөрч чадахгүй. Хойд Солонгос НҮБ-ын тогтоолыг бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллах ёстой" гэж мэдэгдсэн байна. Харин АНУ-

ын Ерөнхийлөгч "Японыг 100 хувь дэмжинэ" гэдгээ илэрхийлжээ. Үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчийн албанд томилогдож, тангараг өргөснөөс хойш БНАСАУ анх удаагаа пуужин харвасан нь энэ юм. Гэвч, АНУ-Японы төрийн тэргүүнүүдийн уулзалттай зэрэгцэн пуужин харвасан нь сануулга өгөх зорилготой байж болзошгүй хэмээн зарим эх сурвалж мэдээлж байна. БНАСАУ Пёнъяны Кусон баазаас пуужин харважээ. БНСУ-ын цэргийнхний талаас мэдэгдэж буйгаар тус пуужин "2500-4000 км"-т тусах чадвартай Мусудан пуужингийн шинэчилсэн загвар ч байж болох бөгөөд чухам ямар загварын пуужин харвасан эсэхийг тогтоохоор ажиллаж буй аж. АНУ-ын цэргийн албан

тушаалтнууд ч БНАСАУ пуужингийн туршилт хийснийг баталжээ. Гэхдээ ямар төрлийн, хэр зайд тусах чадалтай пуужин гэдэг талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй байна. Пуужин харвасны дараа Япон улсын Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ёшихидэ Суга хэвлэлийн бага хурал зарлаж, "АНУ-Японы төрийн тэргүүнүүдийн уулзалтын яг дараа БНАСАУ пуужин харвасан нь дан ганц манай улс төдийгүй бүс нутагт үзүүлж буй өдөөн хатгалга" гэж үзэж буйгаа онцлон тэмдэглэсэн байна. Мөн Пхеньяны талд уг үйл ажиллагааг эсэргүүцэж буйгаа илэрхийлжээ. Ямартай ч, энэ удаагийн пуужингийн туршилтаар завь, хөлөг онгоц живэх гэх мэтээр сөрөг үр дагавар гараагүй аж.

Доналд Трамп өнгөрсөн баасан гарагт Вашингтонд Японы ерөнхий сайд Шинзо Абэтай уулзахдаа Хойд Солонгосын довтолгооноос холбоотнуудаа хамгаалах нь АНУ-ын тэргүүн зэргийн зорилт байх болно гэж мэдэгдсэн юм. Холбоотнууд гэдэгт Япон, Өмнөд Солонгос улсууд багтаж байгаа. Тэгвэл өнгөрсөн шинэ жилийн мэндчилгээндээ Ким Жон Ун өөрийн тив хоорондын баллистик пуужин хөгжүүлэх ажил нь эцсийн шатандаа орсныг зарлаж байв. Тэрбээр АНУ-ын баруун эрэгт цохилт өгөх чадвартай болж байгаагаа энэ үеэр дуулгасан удаатай. Харин энэ удаагийн өдөөн хатгалгыг шинэ ерөнхийлөгч Доналд Трампыг турших зорилготой гэж ажиглагчид үзэж байна.

Дэлхийн хамгийн тарган эмэгтэй мэс засал хийлгэхээр Энэтхэгт очлоо

Манай гаригийн хамгийн хүнд жинтэй эмэгтэй Египетэд амьдардаг. Эман Ахмед Абд Эл Ати гэх 36 настай бүсгүй 500 кг жинтэй бөгөөд бүхэл бүтэн 25 жилийн турш нэг ч удаа гэрээсээ гарч үзээгүй гэдэг. Тэгвэл тэрбээр Энэтхэгийн хамгийн шилдэг гоо сайхны мэс заслын эмчээр мэс засал хийлгэхийн тулд 25 жилийн дараа анх удаагаа гэрээсээ гарч, Мумбайд хүрэлцэн иржээ. Бүсгүйд Энэтхэгийн Дотоод хэргийн сайд Сушма Свараж тусалсан гэдэг. Энэтхэгийн нарийн мэргэжлийн мэс засалч эмч Муффазал Лакдавалатай Эман Ахмедын дүү нь холбогдсон аж. Муффазал Лакдавала эмч "Тэр эмэгтэй намайг дэндүү ихээр өөхөлж таргалсан хүмүүст хагалгаа хийдгийг тандяг хүнээсээ сонссон юм билээ. Тэдний гэр бүл их ядуу учраас Каир хотоос Мумбай руу онгоц хөлсөлж нисэх боломж үгүй юм. Тийм учраас бид гадаад паспорт, визээ өөрсдөө зохицуул, харин тээвэрлэх хөрөнгө мөнгийг манай тал хариуцна гэж тэдэнд хэлсэн" хэмээн ярьсан байдаг. Гэхдээ эмчлүүлэх виз авах нь нэлээд ярвигтай байсан гэнэ. Энэтхэгийн Элчин сайдын яам орон дээрээсээ 20 гаруй жил буугаагүй эмэгтэйд визээ авахаар өөрийн биер эрх ёстой гэж шаарджээ. Харин асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн тулд эмч цахим сүлжээг ашиглан Энэтхэгийн Дотоод хэргийн сайдад хандсан байна. Сайд ч эмэгтэйд тусалцаа үзүүлэхээ амласнаар виз нь олгогдож, 500 кг жинтэй египет эмэгтэй мэс засал хийлгэж, илүүдэл жингүй болох зорилгоор ийнхүү Энэтхэгийн Мумбай хотноо өнгөрөгч баасан гарагт хүрэлцэн иржээ.

Афганистан руу цэрэг нэмж илгээхийг уриаллаа

Лалын босогчдын "Талибан" хөдөлгөөнтэй тэмцэхийн тулд хүн хүчийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна гэж Афганистан дахь АНУ тэргүүтэй олон улсын хүчнийхний командлагч мэдэгдлээ. Генерал Жон Николсон Сенатын танхимын Зэвсэгт хүчин хариуцсан хороонд Афганистаны нөхцөл байдлыг тайлагнажээ. Николсоны хэлснээр, өнгөрсөн онд "Талибан"-ы босогчид халдлага үйлдэх нь

нэмэгдсэнээр Афганистаны Засгийн газар өөрийн хяналтаа тогтоогоод байсан газар нутгийнхаа 15 орчим хувийг алдсан байна. Одоо Афганистанд олон улсын 13 мянга орчим цэрэг байрлаж байна. Афганистаны аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулах үүрэг хариуцлагыг тус улсын дотоодын хүчнийхэнд шилжүүлэхийн тулд тэдэнд зориулан бэлтгэл сургалт

явуулж, зөвлөгөө өгч, туслахад хүн хүч дутагдалтай байгаа учир цэрэг нэмж илгээх шаардлагатай байна гэж генерал хэлжээ. Афганистаны нөхцөл байдлыг тогтвортой болгох талаар ямар бодлого баримтлахаа АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп хараахан мэдэгдээгүй байгаа юм. Цэрэг нэмж илгээх тухай хүсэлтийг Д.Трамп хүлээж авах эсэх нь ажиглагчдын анхаарлыг татаж байна.

Бельгид 70 хүн хорджээ

Бельгийн нийслэл Брюссель хотод өнгөрөгч амралтын өдрүүдэд "Go kart" машины уралдаан зохион байгуулагджээ. Гэвч энэ уралдааны үеэр нүүрстөрөгчийн дутуу исэл агаарт тархаж, 70 орчим хүн хордсны тавынх нь биеийн байдал хүндэрчээ. Осол Брюссель хотын төвөөс зүүн өмнөд зүгт 30 км зайд орших Ваврт шинээр нээгдсэн "Go kart" машины талбайд болсон байна. Хордсон хүмүүс орон нутгийн эмнэлэгт хүргэгджээ. "Берга" агентлагийн мэдээлж буйгаар Вавр тосгоны дарга "Машины талбайд

байсан хүмүүсийг бүгдийг нь нүүлгэн шилжүүлсэн. Ноцтой хэмжээнд хохирсон хүн байхгүй" гэнэ. Уг үйл ажиллагаанд 150 орчим хүн оролцож байжээ. Гэхдээ нүүрстөрөгчийн дутуу исэл агуулсан утаатай холбоотой гомдол тэмцэн болохоос хоёр хоногийн өмнө холбогдох албанд ирж байсныг орон нутгийн хэвлэлд мэдээлсэн байна. Одоогоор албаныхан хорт утаа агаарт тархсан шалтгааныг судалж буй бөгөөд урьдчилсан байдлаар агааржуулалт эвдэрсэнтэй холбон тайлбарлаж байгаа юм байна.

Д.Трамп АНУ-Мексикийн хилд хана барих төсвөө бууруулна



АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп өнгөрөгч бямба гарагт хууль бус цагаачдын эсрэг авч хэрэгжүүлэх бодлогын хүрээнд Мексик-АНУ-ын хилд босгохоор төлөвлөсөн хананы төсвийг бууруулахаа мэдэгджээ. Дотоодын аюулаас хамгаалах яамнаас хана босгоход гарах зардлыг 21.6 тэрбум ам.доллар гэж тооцсон байдаг. Тэгвэл шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп уг зардлыг багасгахаа өөрийн албан ёсны твиттер хуудсаараа дамжуулан мэдэгдсэн байна. Эдүгээ маргаан мэтгэлцээний гол сэдэв болон хувираад буй Мексикийн

хилийн орчимд хана босгох ажил ойролцоогоор гурван жил үргэлжлэх бөгөөд 12-15 тэрбум ам.долларын зардал гарна гэх судалгааг өнгөрсөн сард конгрессын танхимын дарга Пол Райн тэргүүтэй баг тооцож гаргасан байдаг. Тэгвэл үүнтэй холбоотойгоор Трамп "Их гүрний хил хязгаарын бүтээн байгуулалтад зарцуулагдах төсвийг Засгийн газрын анхны таамагласан хөрөнгөөс багасгах боломжтой. Гэхдээ би энэ асуудлыг дахин хэлэлцэхгүй. Хэрэв ингэсэн тохиолдолд F35, Air Force One-той адил төсвийг нь бууруулна" гэжээ.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны хоёрдугаар сарын 9-ний өдрийн 70 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-015491	2010.02.18	Дорноговь	Улаанбадрах, Хөвсгөл	Улаанбадрах-2	Эйч Ди Эл ХХК
2	MV-017210	2012.05.22	Төв	Алтанбулаг	Налгар	Тн Эн энд Юу ХХК
3	XV-018685	2015.07.02	Ховд	Зэрэг, Манхан	Хараа	Монгол таавар ХХК
4	XV-012438	2007.05.04	Ховд	Булган, Үенч	Олон булаг-1	Ашнанлийд ХХК
5	MV-017392	2013.09.30	Баянхонгор	Баян-Овоо	Урт дэл	Идэргөлд ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

ЦАГ ҮЕ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

АШУУИС-ийн нэгдсэн эмнэлэгт ДУРАНГИЙН БҮХ ХАГАЛГААГ ХИЙХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО



Үргэлжлэл.
Түүрүүч нь I нүүрт

Ингэснээр Монголд дурангийн ямар ч төрлийн хагалгааг хийх боломжтой болсон гэнэ. Энэ талаар тус эмнэлгийн мэс заслын ерөнхий эмч Пак Кван Тэ “Мэс засалд хэрэглэдэг дурангийн аппарат гэдэг яг л хүний нүдтэй адилхан. Нэг үгээр хэлбэл, мэс заслын эмчийн нүд нь болдог гэсэн үг. Тиймээс дурангийн аппарат маш чухал юм. Аппарат сайн байх тусам эмч сайн харж, хагалгааг аюулгүй амжилттай хийх боломж бүрддэг. Манай эмнэлэгт суурилуулсан дурангийн шинэ аппаратыг тусламжтайгаар Монголд хийх боломжгүй байсан дурангийн бүх л хагалгааг хийх боломжтой болсон” гэв. Эмч нарын чадвар сайн хэдий ч сүүлийн үеийн дэвшилтэт тоног, төхөөрөмж байхгүйн улмаас иргэд зарим хагалгааг БНСУ-д хийлгэх нь бий. Дурангийн аппаратыг тусламжтайгаар хийдэг зарим хагалгааг ч сарын өмнөхөн манай улсад хийх боломжгүй байжээ. Тухайлбал, нойр булчирхай, дэлүү, бөөрний дээд булчирхай, бүдүүн гэдэс тайрах болон ходоодны зарим хагалгааг хийх боломжгүй тул БНСУ-ыг зорин өндөр үнэтэй хагалгаанд ордог байв. Тэгвэл энэхүү шинэ аппаратыг суурилуулснаар иргэдэд хэд хэдэн боломжийг нээж өгч байгаа гэнэ. Гадаадын аль нэг улсад эмчилгээ хийлгэхэд ирж, очих онгоцны тийзнээс эхлээд зардал мөнгө их зарцуулдаг. Эмнэлгийн төлбөр, хагалгааны төлбөр,

хоол, унд, эмний мөнгө гээд 100 гаруй сая төгрөг зарцуулах нь энүүхэнд. “Охин минь гадаадад зүрхний хагалгаанд яаралтай орох хэрэгтэй байна. Эмчилгээний зардалд 80 сая төгрөг шаардлагатай. Бидэнд туслаач” гэх мэдээллийг бид фэйсбүүк, твиттерээр олонтаа хардаг. Энэ мэтчилэн мөнгөтэй нэг нь холын орныг зорьж эмчилгээ хийлгэж, зарим нэг нь сайхан сэтгэлт хүмүүсийн тусламжтайгаар амьдралын төлөө тэмцэж байдаг. Харин мөнгөгүй нэг нь улсын болон хувийн эмнэлгээс ч эрүүл мэндийн үйлчилгээ авч чадалгүй хорвоог орхиж буй харамсалтай жишээ олон бий. Үүний дунд гадаадад дурангийн хагалгаанд орох шаардлагатай хүмүүс ч байсан байж магадгүй. Харин одоо заавал гадаадын аль нэг улсыг зорин өндөр үнээр хагалгаанд оролгож, эх орондоо хямд, болмжийн үнээр дурангийн бүх төрлийн

хагалгааг хийлгэх боломжтой болжээ. Германд үйлдвэрлэсэн FENCER III дурангийн аппаратыг суурилуулснаас хойш хэд хэдэн хүндхэн хагалгааг тун амжилттай хийжээ. Манай сурвалжлах хэсгийг тус эмнэлэгт очих үед Пак Кван Тэ эмч дурангийн дөрвөн хагалгаатай байв. Эдгээрийн дунд томоохон хагалгаа байсан нь Монголд өмнө нь хийгдэж байгаагүй шархны эвэрхийг дурангаар авах хагалгаа байсан юм. Энэ мэтчилэн хүнд хагалгааг эх орондоо хийлгэх боломжтой болжээ. Пак Кван Тэ эмч манай улсад 15 жил ажиллаж байгаа бөгөөд Монголд 1530, нийт 2500 орчим дурангийн хагалгааг гардан хийсэн туршлагатай эмч юм. Түүний талаар тус эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, профессор Д.Даваадорж хэлэхдээ “Манай сургуулийн эмнэлэгт ажиллаад гурван жил болж байна. Пак Кван Тэ

...Хэрвээ Монголд хийлгэх боломжгүй дурангийн хагалгаа хийлгэх шаардлагатай байгаа бол АШУУИС-ийн нэгдсэн эмнэлэгт хандах боломжтой аж. Ингэснээр та эх орондоо хямд зардлаар эмчилгээ авах юм байна. Энэ мэтчилэн Монголын анагаах ухааны салбарт ахиц дэвшил гарсаар байна...

хийж, сургалт, судалгаа хийдэг профессор юм. Пак Кван Тэ профессорыг гагалдаж манай хэд хэдэн залуу мэс засалч суралцаж байгаа. Тэд барууны мэс заслын эмчийн олгох дамжааны стандартын дагуу сургалт авч байна. Пак Кван Тэ эмч мэс заслын хагалгаанаас гадна манай залуу эмч нарыг БНСУ-ын томоохон эмнэлгүүдтэй холбож өгч, мэс заслын эмчийн сургалтын дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж өгч байгаа. Манай Монголын олон өвчтөнүүд Пак Кван Тэ эмчийг мэднэ. Тэр дундаа бөөрний эмгэгээр өвдсөн диализ хийлгэж байгаа хүмүүс маш сайн мэддэг. Учир нь Пак Кван Тэ эмчийн хийсэн судасны мэс заслууд нь хүндрэл өгдөггүй. Маш удаан тогтвортой байдаг” гэв. Пак Кван Тэ эмчийн Монголчуудын төлөө хийсэн бас нэг томоохон ажил нь FENCER III дурангийн аппаратыг тус эмнэлэгт авчирсан явдал ажээ. Тэрбээр, FENCER III дурангийн аппаратыг суурилуулснаар Монголд хийх боломжгүй дурангийн хагалгааг хийж, иргэд илүү хямд зардлаар эх орондоо эмчилгээ хийлгэх болсон гэдгийг онцолсон юм. Хэрвээ Монголд хийлгэх боломжгүй дурангийн хагалгаа хийлгэх шаардлагатай байгаа бол АШУУИС-ийн нэгдсэн эмнэлэгт хандах боломжтой аж. Ингэснээр та эх орондоо хямд зардлаар эмчилгээ авах юм байна. Энэ мэтчилэн Монголын анагаах ухааны салбарт ахиц дэвшил гарсаар байна. Иргэд дурангийн хагалгаа хийлгэхийн тулд заавал гадаадын улсыг зорих шаардлагагүй болсон гэдгийг энд дахин онцолъё. Мөн тус эмнэлэг “Эрт оношилж, эрүүл мэндээ хамгаалъя” аяны хүрээнд байгууллага, хувь хүнд зориулсан “Урьдчилан сэргийлэх үзлэг”-ийн багц шинжилгээндээ 20 хувийн хөнгөлөлт үзүүлж байгаа юм байна.



Аймаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

Сайншанд сумын 2, 3, 4 дүгээр баг тоглоомын талбайтай болов

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн төлөвлөгөө”-ийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд тусгагдсаны дагуу нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах, бага насны хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх зорилгоор Сайншанд сумын 2, 3, 4 дүгээр багуудад дөрвөн тоглоомын талбайг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлжээ. Тус тоглоомын талбайг “ТЭТҮ” ХХК-иар гүйцэтгүүлсэн бөгөөд нийт 73.3 сая төгрөгийн хөрөнгөөр бүтжээ. Тус тоглоомын талбайн нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 10-нд гуравдугаар багийн “Залуус” хорооллын дэргэдэх тоглоомын талбайд болсон байна. Нээлтэд аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзориг, Сайншанд сумын Засаг даргын орлогч Г.Ганбат болон Сайншанд сумын гуравдугаар багийн иргэд оролцлоо.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

“Залуу малчдыг дэмжих аян” эхэллээ

Монгол улсын хамгийн залуу УИХ-ын гишүүн, Монголын морин спорт, залуу уяачдын холбооны Ерөнхийлөгч, Д.Гантулгын санаачлан хэрэгжүүлж буй “Залуу малчдыг дэмжих аян” Говьсүмбэр аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тус аяны хүрээнд Говьсүмбэр аймгийн дуу бүжгийн “Боржигин” чуулгад УИХ-ын гишүүн Д.Гантулга төрийн байгууллагуудын 250 гаруй албан хаагчидтай “Манлайлын ур чадвар” сэдвээр лекц уншиж уулзалт хийлж, аймгийн ГБХЗХГ-ын дарга Ц.Оюунбилэг энэ сарын

ДАРХАН-УУЛ АЙМАГ

Дархан-Уул аймгийн М.Уайхан Улсын аварга малчнаар тодорлоо

21 аймаг, нийслэлээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлсэн материалыг 75 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, 103 малчныг “Улсын аварга малчин”, таван малчныг “Улсын хошой аварга”, таван саальчинг “Улсын аварга саальчин”, таван фермерыг “Улсын аварга фермер”, 12 аж ахуйн нэгжийг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, 21 иргэнийг “Улсын тэргүүний тариаланч”-аар шалгаруулахаар Засгийн газрын хуралдаанаас шийдвэрлэсэн байна. Аварга малчид 26-78 насныхан бөгөөд сүүлийн гурван жил сум, орон нутгийнхаа амьжиргааны төвшин доогуур, цөөн малтай 400 гаруй өрхөд 32 мянга гаруй толгой мал өгч малжуулжээ. Мөн зах зээлд 42 мянга гаруй, үржилд 17 мянга гаруй мал борлуулсан байна. Малчид сүүлийн гурван жил нийт 18 тэрбум төгрөгийн орлого олж, мал аж ахуйн салбарт нэг тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. “Улсын аварга тариаланч хамт олон”-оор шалгарсан 12 аж ахуйн нэгжийн 11 нь үр тариа, нэг нь төмс, хүнсний ногооны

тариалан эрхэлдэг бол “Улсын аварга тариаланч” 21 иргэний 14 нь төмс, хүнсний ногоо, долоо нь үр тарианы аж ахуйн нэгжид механикжуулагчаар ажилладаг байна. Аваргын болзол хангасан малчид, иргэд, тариаланчид, хамт олны шагнал /цом, тэмдэг, үнэмлэх, өргөмжлөл, улаан халз бүхий таван ханатай гэр/ -ыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын баярын өмнө гардуулах юм.

- 1. “Улсын аварга малчин”-аар:**
-Дархан-Уул аймгийн Хонгор сумын Зулзага багийн малчин Мазангийн Уайхан, Дархан сумын Малчин багийн малчин Бамбадайн Хаянхярваа;
- 2. “Улсын аварга тариаланч хамт олон”-оор:**
-Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Өглөгчийн хэрэм” ХХК;
- 3. “Улсын аварга тариаланч”-аар:**
-Дархан-Уул аймгийн Орхон сумын иргэн Бямбажавын Жаргалсайхан нар шалгарчээ.

ОРХОН АЙМАГ

Сүлжээний бизнес нэрийдлээр иргэдийг хохироосон этгээд 10-15 жил хорих ял эдэлнэ

Аймгийн Цагдаагийн газарт 2017 он гарсаар сүлжээнд элсэж мөнгөө авч чадахгүй хохирсон гэх гомдол мэдээлэл 20 гаруй иргэнээс ирж, шалгагдаж байна. Учир нь эдийн засаг хүндрэлтэй байгаа энэ үед төрөл бүрийн сүлжээ нэрийн дор иргэдийн мөнгийг авч хохироох явдал гарсаар байгаа юм. Тухайлбал иргэд 62.500 төгрөгөөр элсээд мөнгөө 187.500 өсгөж авдаг энэ төрлийн сүлжээнд орж хохирох явдал гарч байгааг хууль хяналтын байгууллагуудаас анхаарууллаа. Сүлжээг ашиглаж, дороо хүн элсүүлж, анх элссэн хүн цалин ашиг авдаг энэ хэлбэрийн үйл ажиллагааг санхүүгийн пирамид буюу санхүүгийн луйвар гэж нэрлэдэг. Энэ нь Монгол Улсын хуулиар хорьтой. Өөрөөр хэлбэл, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж, ашиг хонжоо олох үйл ажиллагааг хориглоно гэсэн хуулийн заалттай юм. Мөн ямар нэгэн бараа бүтээгдэхүүнийг сүлжээгээр дамжуулан худалдан борлуулдаг хэлбэрийг сүлжээний бизнес гэж нэрлэдэг байна. Борлуулалтын хэлбэр нь пирамид хэлбэртэй байж болно. Харин иргэдийн хувьд ямар нэгэн бараа бүтээгдэхүүн зарж борлуулахгүйгээр, дороо 1-2 хүн элсүүлж, ажил хийхгүйгээр мөнгөтэй болно гэж итгэж хохирох явдал олон гарч байна. Манай улсад өнөөдрийн байдлаар гадаад, дотоодын нийлсэн 20 гаруй сүлжээний бизнесийн компани үйл ажиллагаа явуулдаг гэсэн албан бус судалгаа гарсан. Тэдгээрээс эрчимтэй үйл ажиллагаа явуулж иргэдийг олноор нь хохироох болсон нь “G-time” төсөл, “62500-ын Ultimate Mongolia” юм. Энэ төрлийн гэмт хэрэгтэнд холбогдох Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 нь “Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн заалттай. Гэвч ихэнх тохиолдолд иргэдийн мөнгийг гадаадын улс орны ямар нэг тодорхой бус дан руу шууд хийдэг учир хариуцах эзэнгүй болж иргэд мөнгөө эргүүлж авч чадахгүй хүрдэг. Иймд сүлжээний бизнест итгэж мөнгөө алдаж, хохирогч болохгүй байхыг иргэд та бүхэндээ сэрэмжлүүлж байна.

Орхон аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс

СОНИРХУУЛАХАД

Ахмад настангаа үзүүлж БУЯН БОЛООРОЙ

Төвдийн цаст нэгэн гацаанд баян худалдаачин Шаравжанцангийн хүү Тойвоо, охин Бидагийн хамт амьдран сууна. Хүүг долоон нас хүрэхэд эцэг нь насан эцэслэж, ээж Нянца Гаржан хоёр хүүхдийн хамт бэлэвсрээ. Эцгийн эд баялаг авга ах түүний эхнэрийн мэдэлд очиж тэд ядуугийн дээдийг, зовлонгийн ихийг амсана. Энэ байдлыг тэвчишгүй учир хүү Тойвоог хараалч болгохоор алсад мордуула. Хас бөгжит хилэнт хаанд /Юндэн Тожил/ шавь оруулснаар хараалыг хүчтэй хийж, авга ахын хүүгийн хурим найран дээрх 35 хүний амийг авч одно. Гэвч өшөө хорлоо тайлсан Тойвоог үйлдсэн хилэнцэт нүглийн үрийг хар толгойдоо үүрч сэтгэл нь асар ихээр шаналан зовно. Тэр Марва Лозава багштай учирна...

Энэ бол Монгол Улсын хүүхэлдэйн театрын ээлжит бүтээл буюу алдарт "Мял Богдын намтар" жүжиг юм. Тус хамт олон тахиа жилийн босгон дээр буюу энэ сарын 15-аас эхлэн 18:00 цагт дээрх

жүжгийг тоглох гэж байна. Ахмад настан, өвөө эмээ нар маань энэхүү түүхэн хүний намтрыг бүгд мэддэг, бүр бишрэн шүтдэг. Тиймээс тус театрынхан энэ удаагийн тоглолтоо азай буурлууддаа хүндэтгэл үзүүлэн толлуулах гэж байгаа аж. Мөн жүжгийн тасалбарыг 5000 төгрөг болгож бэлэг барьж байгаа гэнэ. "Мял Богдын намтар" зохиолыг СГЗ Цоодолын Хулан цомнол болгон бичиж, тус театрын найруулагч СТА М.Ариунтуяа найруулж, Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Б.Мөнхболд, СТА бүжиг дэглээч Д.Энхгэрэл болон хүүхэлдэйн театрын нийт уран бүтээлчид оролцож тайзнаа амилуулан үзэгч түмний хүртээл болгож байна. Энэхүү жүжгийг алтан унжлагат хэмээх гал тахиа жилийн босгон дээр өвөө эмээ, ахмад настандаа үзүүлвэл буян болно биз ээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг
96637501, 96981669,
321669 утсаар аваарай.

Л.НАСАНБУЯН тун удахгүй ҮРИЙН ЗУЛАЙ ҮНЭРЛЭНЭ

"Оддын эрэлд-2" тэмцээний тэргүүн байрын шагналт, "Л.Балхжавын дуут хэн сайн дуулах вэ" уралдааны шилдэг 15 оролцогчийн нэг дуучин Л.Насанбуян дуу хөгжим сонирхогчид андахгүй. Насаа бол рок поп ертөнцийн сор болсон МУГЖ Б.Сарантуяагийн цор ганц шавь болсон азтай бас авьяаслаг нэгэн. Харин тэрбээр "Урлагийн ертөнцийг боксын ринг гэж төсөөлвөл олон жилийн турш дасгал сургуулилт хийж, өөрийгөө хөгжүүлж, чангаруулж яваа залуу, эрч хүчтэй шинэ тамирчин" хэмээн өөрийгөө тодорхойлж байсан цаг саяхан.

Царайлаг бас шаггүй авьяастай дуучин бүсгүй нэгэнтээ залуус заавал царайлаг байх албагүй, гагцхүү сайхан сэтгэлтэй, мэдлэг боловсролтой, авхаалжтай сэргэлэн байх шаардлагатай, царайг бол жаахан тордоод л өөд татчихна гэж хэлж байсан удаатай. Тэгвэл тэрбээр хайрын эзнээ олсон төдийгүй тун удахгүй үрийн зулай үнэрлэж, ээж болох гэж байгаа юм билээ. Тэрбээр хэдийгээр төрөх дөхсөн ч энэ сарын 10-нд болсон багшийнхаа "Аргагүй амраг" тоглолтын зохион байгуулалтын ажлыг хийж, өөрөө ч ая дуугаа өргөхийн зэрэгцээ, хоёр цагийн турш өндөр өсгийт дээр зогсч чадсан нь олныг гайхшируулаад амжсан шүү.



ТОГЛОЛТЫН ЦАГ



Сараагийн "Аргагүй амраг" -тай өнгөрүүлсэн үдэш саак байлаа

Э.ТУУЛ

16-хан насандаа урлагт хөл тавьж, "Мөнгөн хараандаа" хамтлагаас гараагаа эхэлж байсан дуучин Б.Сарантуяа Монголын рок поп урлагт аль хэдийнэ орон зайгаа эзлэж, 30 жилийн түүхийг бүтээж чаджээ. Мөн тэрбээр Монголын рок поп урлагт анхны гэх тодотголтой олон шинэчлэлийг авчирсан нэгэн. Тэрбээр урлагт зүтгэсний 10 жилийн ойгоо 1996 онд тэмдэглэж байсан төдийгүй "Аргагүй амраг" хэмээх этник цомгоо өлгийдөн авч, цомгийн баяраа Сингапурт тэмдэглэж байв. Монголын рок поп урлагт 20 жилийн өмнө тэсрэлт хийсэн "Аргагүй амраг" цомогт этник ардын дуунуудаас гадна поп хагатайн "Хайрын бурхан", "Хэн юм бэ", "Чи алзахгүй", "Сэхүүн салхи", "Супермэн" тэргүүтэй шилдэг хитүүд нь багтсанаараа тухайн цаг үедээ ч хэн дуртай нь олж авч чадаагүй нандин эд байсан гэдэгтэй санал нийлэх биз ээ. Түүний уянгалаг бөгөөд хүчтэй хоолойгоор сонсогч фонуудийнх нь сонорт хүрсэн олон сайхан уран бүтээлийнх нь дээжиг эдүгээгээс 20 жилийн өмнө эгшиглэж байсан "Аргагүй амраг" этник тоглолтод нь дуулагдаж байв.

Тиймдээ ч 20 жилийн дараа ийн хав дарсан хачин сайхан "жоор"-оо задалж, 20 жилийн өмнөх тэр л үед фонуудийг урин залсан юм. ХХ зууны манлай дуучин, 30 жил тайз эзэгнэсэн энэ л эрхэмсэг хагатай алдарт "Аргагүй амраг"-аа дахин сэргээхдээ гэгээн хайрын баярыг тохиолдуулан, ганцхан удаа "Корпорэйт" зочид буудлын "Corporate convention center"-г энэ сарын 10-нд дахин тоглолоо. Монголчууд хошин шогийн тоглолтоос өөр үзэх үзвэргүй, уйдаж залхаад байгаа энэ үед поп хагатайн "Аргагүй амраг" ёстой л цаг үе мэдэрч чадсан гэхэд болно. Яг үнэндээ Б.Сараагийн фонууд хамгийн азтай нь. 30 жил тасралтгүй уран бүтээл хийсэн, зүгээр суудаггүй, жил бүр тоглолт хийдэг түүн шиг дуучин үгүй гэвэл хэтрүүлсэн болохгүй. Аргагүй л "юугаар баян, түүгээрээ дайла" гэгчээр хэдий СТӨ-ний дэд захирал болсон ч хажуугаар

нь уран бүтээлээ орхилгүй, үзэгч олноо уйдаадаггүй тэр хэвээрээ гялалтаж байсныг дурьдах нь зүйтэй.

Тиймээс ч түүний "Аргагүй амраг"-т гал халуун фонууд нь хүрэлцэн ирсэн нь тэр биз. Түүний тоглолтод хөтөлгөчийн ч хэрэг алга. Тэр бол өөрөө амьд домог учраас дуу бүтсэн түүх, өөрийн сэтгэгдлээрээ л тоглолтоо амилуулж байв. Амьд хөгжмийн "Random", үндэсний хөгжмийн "Олонхи" хамтлаг, дуучин Л.Насанбуян болон ЦЦБЭЧ-ын бүжигчид, "Харанга" хамтлагийн дуучин Х.Лхагвасүрэн нар ч түүний тоглолтод хүрэлцэн ирж, поп хагатайтай нэгэн үдийг өнгөрүүлсэн юм. Тэрбээр "Аргагүй амраг" цомогт багтсан "Ихэр саран", "Салхины хээ", "Миний ээж тэмээчин" дуунуудаасаа гадна "Олонхи" хамтлагийнхантай хамтран бүтээсэн "Зоргоороо амраг", ятгын дөрвөлтэй хамтран дуулсан бүтээлүүд, "Random" хамтлагийн гитарчин, дуучин Чойжоотой хамтарсан "Хаврын ганц улиас" зэрэг олон сайхан бүтээл нь энэ үдэш эгшиглэсэн нь фонуудийнх нь сэтгэлийг хөдөлгөж байв. Алдарт "Хайрын бурхан", "Сэхүүн салхи" мэндэлсэн "Аргагүй амраг" концерт Сараагийн фонуудийн дурсамжийг ёстой л нэг хөглөлөө. Түүнийг эргэлзээгүйгээр Монголын урлагт тодорсон од гэдгийг монголчууд хүлээн зөвшөөрдөг. Хоолойн чадлаас гадна дууны дотоод гоо сайхныг мэдэрч, илэрхийлдгээрээ урлагийн томчуудаас өндөр үнэлгээ авдаг Б.Сарантуяагийн "Аргагүй амраг" дахин сэтгэлд хоногшин үлдлээ. Түүний нэгэн цагт "Удаан хугацаанд хүлээн зөвшөөрөгдөж тайзан дээр уран бүтээл тоглогдоно гэдэг маш хэцүү. Байнга тайзан дээр дуулахгүй ч миний хувьд фонуудийнхээ хүсэн хүлээсэн хүсэмжит дуучин байхын төлөө зүтгэсэн. Эргээд харахад 30 жилд 21 цомог гаргасан байна. Дайнд гавьяа байгуулаад ирсэн цэрэг одон медалиудаа энгэртээ шажигнуулдаг бол би цомгуудаа шажигнуулж, өөрөөрөө бахархмаар байна" гэж байсан нь эдүгээ биеллээ олжээ. Тэр бол аргагүй л зууны манлай, зоргоороо бүсгүй юм даа.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -6
Шөнө -17

Нөгөөдөр
Өдөр -10
Шөнө -19

Өдрийн
Зурхай

ӨВЛИЙН АДАГ
ЦАГААГЧИН ҮХЭР
САРЫН ГУРВАН ХӨХ
МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН
ХОНЬ ӨДӨР

Наран ургах шингэх:
07.53-18.12

Үс засуулбал:
Эд малын гарлагатай.



Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсоод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Бидэнд тохиолдсон

КҮНДЭХН ХӨГТЭЙ
ЯВДЛУУД

Ganjavkhan Chadraabal

Өдөр Энхтайваны гүүрны баруун талд гэнэт цагдаа гараад ирвээ. Нүдэн дээр нь бүсээ татаад л, арай гэж амжиж зүүгээд зогсолт "Та одоо хөдлөхдөө л өөрийгөө хайрлаж бай л даа. Намайг харангуутаа учиргүй гэнэт өөрийгөө хайрлах юм" гээд инээгээд явуулсан нь өдөржин хааяа бодогддог. Сайхан энергитэй гоё санагдлаа. Жолооч нар аа, цагдаа харангуутаа гэнэт өөрийгөө хайрлахаа больцгооё, над шиг.



ТЭНГИС ХАЙРЫН ШУУДАН

ТЭНГИС
КИНО ТЕАТР

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН САЙХАН СЭТГЭЛИЙН
ҮГЭЭ ИЛ ЗАХИДЛААР БИЧИЖ ТЭНГИС КИНО ТЕАТР ДОТОР
БАЙРШИХ ХАЙРЫН ШУУДАНД ХИЙНЭ ҮҮ

3 ХОС ШАЛГАРУУЛЖ 2-Р САРЫН 14-НД

- "FIFTY SHADES DARKER" УСК-ны хос урилга
- "ДЭЛГЭЦЭЭР МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЭХ" эрхийн бичиг
- "PREMIUM HOTEL" нэг оройг хамт өнгөрүүлэх эрхийн бичгээр тус тус шагнана.

Захидалдаа холбоо барих утасны дугаараа үлдээнэ үү.

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН ГОЁ СЮРПРИЗ БАРИХ БОЛОМЖ

2017.02.08-13 хүртэл
УТАС: 7000-8070